

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Хавсралтад дурдсан нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагуудын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2.Тогтоолын биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

Санхүүгийн зохицуулах
хорооны 2008 оны 48 дугаар тогтоолын хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛГОСОН БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГЫН НЭРС

	Банк бус санхүүгийн байгууллагын нэрс	Гүйцэтгэх захирлын нэр	Үйл ажиллагааны төрөл
1	“Хан буурал кредит ББСБ” ХХК	С.Дагвадорж	Зээл
2	“Гурван бар кредит ББСБ” ХХК	Ц.Отгонзаяа	Зээл